



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

**“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨХХ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ.
2023 он**

**“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨХХК-ИЙН
2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
АЖЛЫН ТАЙЛАН**

2023.12.15

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ:

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, холбогдох мэдээллээр хангахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг тус тус баримталсан.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК–ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийг **92,4%**, “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэлэв.

Тус компани нь 2023 онд 30 зорилтын хүрээнд 61 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд нийт арга хэмжээний гүйцэтгэлийг авч үзвэл 100 хувьтай 48; 90 хувьтай 2; 70 хувьтай 8; 50 хувьтай 2; 0 хувьтай 1 арга хэмжээ байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Хүснэгт-1

№	Гэрээнд туссан арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн түвшин						Хэрэгжилтийн хувь
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	Арга хэмжээ	61	48	2	8	2	-	1	92,4%

Хэрэгжилтийг зорилт, арга хэмжээ тус бүрээр харуулбал:

Д/д	Арга хэмжээ	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ				
1.1 Нийслэлийн “Хан-Уул” дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хэрэгжих “Солонго 1, 2” төслийн барилгын талбайн бэлтгэл ажлыг хангаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх				
1.1.1	Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 116 дугаар тушаал болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд “Солонго 1, 2” төслийг	Төслийн орон сууцны барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах	Монгол Улсын Засгийн газрын 2022.11.30-ны өдрийн 439 дүгээр тогтоолоор “Солонго 1, 2” төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүргийг “Төрийн худалдан авах ажиллагааны газар”-т даалгаснаар 12.13-ны өдөр	100

	хэрэгжүүлэх нэгжийн үүргийг гүйцэтгэж, төслийн хэрэгжилт болон Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;	ажилд Төрийн худалдан авах ажиллагааны газарт дэмжлэг үзүүлэн ажилласан байна.	үнэлгээний хороо байгуулагдсан. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс 2022, 2023 онуудад шаардлагатай бүх ажлуудад дэмжлэг үзүүлэн ажилласан. Төслийн ерөнхий гүйцэтгэгч компаниар БНСУ-ын "Колон Глобал" корпораци шалгарч БХБЯ-тай 2023 оны 8 дугаар сард гэрээ байгуулан, төслийн талбайн бэлтгэл ажлыг 9 дүгээр сараас эхлүүлсэн.	
1.1.2	"Солонго 1, 2" төслийн техникийн баримт бичгийн бүрдлийг хангах;	Төслийн хүрээнд хийгдэх инженерийн шугам сүлжээний ажлын техникийн нөхцөлүүдийн хугацаа сунгагдсан байна.	"Солонго-1, 2" төслийн хүрээнд хангагч байгууллагуудаас олгосон дулаан, цахилгаан, холбоо, ус хангамж, ариутгах татуургын техникийн нөхцөлүүдийг 2023 оны 4, 5, 8, 10 дугаар сард сунгуулан авсан. Төслийн талбайд хийгдэх түр цахилгаан хангамжийн ажлын зураг төслийг "Түвшинжин" ХХК-иар гүйцэтгүүлж, 2023.07.07-ний өдрийн 1097/2023 дугаартай Барилгын хөгжлийн төвийн магадлалаар батлуулан авсан. "Солонго-1, 2" төслийн БОТБҮнэлгээ, БОННҮнэлгээний ажлуудыг "Грен солюшн консалтинг" ХХК-аар гүйцэтгүүлж, Нийслэлийн байгаль орчны газраар 2023 оны 10 сард батлуулан авсан. "Солонго-1, 2" төслийн ГТБЧХБаталгааны ажлыг "Грен солюшн консалтинг" ХХК-аар гүйцэтгүүлж, 2023.10.16-ны өдөр ГХГЗЗГазраар батлуулан авсан. "Солонго-1" төслийн талбайн газрыг "Буянт-Ухаа 2" хорооллын газраас салгах ажлыг зохион байгуулж, Нийслэлийн Засаг даргын 2023.08.23-ны өдрийн А/954 тоот захирамжаар газрын гэрчилгээг шинэчлэн авсан.	100
1.1.3	"Солонго 1, 2" төслийн талбайг түр цахилгаан хангамж, түр усан хангамжаар хангах бэлтгэл ажлыг хангах;	Төслийн хэмжээнд шаардлагатай байгаа түр цахилгаан хангамж, түр усан хангамж татах ажлын бэлтгэл ажлыг хангасан байна.	Төслийн орон сууцны барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний Ерөнхий заалтын 4.19-т "Гүйцэтгэгч нь төслийн барилга угсралтын ажилд ашиглагдах цахилгаан болон усан хангамжийг хариуцна" гэж заасан бөгөөд төслийн ерөнхий гүйцэтгэгч компаниар шалгарсан БНСУ-ын "Колон Глобал" корпораци нь 2023 оны 10 дугаар сараас төслийн талбайн түр цахилгаан хангамж татах ажлыг эхлүүлсэн.	70
1.2 Нийслэлийн "Хан-Уул" дүүргийн 4 дүгээр хороо, гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих "Эко Яармаг-1" төслийн барилгын талбайн бэлтгэл ажлыг хангаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх				
1.2.1	"Эко Яармаг-1" төслийн эхний ээлжийн барилга	Төслийн эхний ээлжийн 5 блок барилгын	Төслийн гүйцэтгэгч "Түм арвижих ХХК, "УБАЗБК" ХХК-ийн түншлэл нь барилга угсралтын ажилд	70

	угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах;	угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж, хувийн хэвшилд дэмжлэг үзүүлсэн байна.	шаардагдах материалын татан авалт, техник, тоног төхөөрөмж, ажлын төлөвлөгөө зэрэг бэлтгэл ажлыг хангаж, түр барилга байгууламжийг барилгын талбайд байршуулсан. Төслийн талбайн түр цахилгаан хангамж татах, эхний ээлжийн 4 блок барилгын суурийн асгаас шороог зөөх ажлыг 2023 оны 4-7 дугаар саруудад хийж дууссан. Газар шорооны ажлыг хийх явцад хөрсний ус гарсантай холбоотойгоор ус зайлуулах ажлыг зохион байгуулан барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг бүрэн хангасан.	
1.2.2	“Эко Яармаг-1” төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг шинэчлэх ажлыг гүйцэтгэгч байгууллагатай хамтран зохион байгуулах;	Төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын шинэчилсэн зураг төсөлтэй болсон байна.	Төслийн гүйцэтгэгч “Түм арвижих ХХК, “УБАЗБК” ХХК-ийн түншлэл нь барилга угсралтын ажилд шаардагдах материалын татан авалт, техник, тоног төхөөрөмж, ажлын төлөвлөгөө зэрэг бэлтгэл ажлыг хангаж, түр барилга байгууламжийг барилгын талбайд байршуулсан. Төслийн талбайн түр цахилгаан хангамж татах ажлыг 2023 оны 4-5 дугаар сард хийж дуусган, Улсын комисст хүлээлгэн өгсөн. Төслийн эхний ээлжийн барилгын суурийн газар шорооны ажлыг 2023 оны 5 дугаар сард эхлүүлж, 4 блок барилгын суурийн шороог бүрэн ухаж дуусгасан бөгөөд 1 блок барилгын суурийн хэсэгт шинээр 2 айлд газар олгосноос шалтгаалан тус ажил хийгдээгүй. Газар шорооны ажлыг хийх явцад хөрсний ус гарсантай холбоотойгоор ус соруулах ажлыг 8, 9 дүгээр сард зохион байгуулан ажилласан.	50
1.2.3	“Эко Яармаг-1” төслийн эхний ээлжид хамрагдсан 26 иргэнтэй түр суурьшуулах зардлын гэрээг шинэчлэн байгуулах;	Төслийн эхний ээлжид хамрагдсан 25 иргэнтэй холбогдох гэрээг шинэчлэн байгуулж, 2023 оны түр суурьшуулах зардлыг олгосон байна.	Төслийн хүрээнд нийт 26 иргэнтэй түр суурьшуулах зардал олгох гэрээг 2023 оны 2 дугаар сард шинэчлэн байгуулж, 2023 оны түр суурьшуулах зардал болох 312,0 сая төгрөгийг 2023 оны 11 сард бүрэн олгож дууссан.	100
1.2.4	“Эко Яармаг-1” төслийн хоёрдугаар ээлжид хамрагдсан 65 нэгж талбарын газрыг чөлөөлж, хог хаягдлыг цэвэрлэх, хөрсний ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг гүйцэтгүүлэх;	Төслийн хоёрдугаар ээлжийн 65 нэгж талбарын газрыг чөлөөлөх ажлыг зохион байгуулсан байна.	Төслийн хоёрдугаар ээлжийн талбай болох нийт 65 нэгж талбарын газрыг бүрэн чөлөөлөх бэлтгэл ажил хангагдсан бөгөөд 2023 онд хийгдсэн Үндэсний аудит газрын зүгээс аудит хийн төслийн хүрээнд газар чөлөөлөлтөд 2014-2015 онд олгосон 1,417.9 тэрбум төгрөгийн үнэ бүхий орон сууцыг	0

			хууль бус замаар бусдад шилжүүлсэн байх эрсдэлтэй байна гэж дүгнэн, төслийн хоёрдугаар ээлжийн газрыг чөлөөлөх ажлыг тодорхойгүй хугацаагаар түр зогсоосон.	
1.3 Нийслэлийн “Хан-Уул” дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хэрэгжих иргэдийн орлогод нийцсэн орон сууцны “Залуус-1” төслийн барилгын ажлыг эхлүүлэх.				
1.3.1	“Залуус-1” төслийн гадна инженерийн 1-р хэлхээний шугам сүлжээний угсралтын ажлын гүйцэтгэлд хяналт тавих;	Төслийн эхний ээлжийн шугам сүлжээний угсралтын ажил дуусаж, инженерийн шугам сүлжээгээр 50 хувьтай хангагдсан байна.	“Залуус-1” төслийн эхний ээлжийн 936 айлын орон сууцны барилгын инженерийн дэд бүтцийн угсралтын ажил 2022 онд эхэлсэн бөгөөд 2023 оны 4 дүгээр сараас үргэлжлэн явагдсан. 2023 оны Улсын төсөвт нийт 7,4 тэрбум төгрөг суугдаж, гүйцэтгэлийн явцад угсралтын ажлын техник хяналтыг “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-тай хамтран хэрэгжүүлсэн. Угсралтын ажлын явцын тайланг БХБЯаманд сар бүр нэгтгэн хүргүүлж, мэдээллээр хангаж ажилласан.	100
1.3.2	“Залуус-1” төслийн техникийн баримт бичгийн хангах;	Төслийн хүрээнд хийгдэх шугам сүлжээний ажлын холбогдох техникийн нөхцөлүүд сунгагдсан байна.	“Залуус-1” төслийн хүрээнд шинээр баригдах дулааны станцын барилгын цахилгаан, холбоо, ус хангамж, ариутгах татуургын техникийн нөхцөлийг 2023.03.03-ны өдөр хангагч байгууллагуудаар тус тус батлуулан авсан.	100
1.3.3	“Залуус-1” төслийн хүрээнд шинээр баригдах Дулааны станцын зураг төсөл болон хоёрдугаар ээлжийн шугам сүлжээний ажлын зураг төслийг батлуулах;	Төслийн хүрээнд хийгдэх инженерийн шугам сүлжээний ажлын иж бүрэн зураг төсөл, төсөвтэй болсон байна.	Төслийн инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл нь 2 үе шаттай хийгдсэн бөгөөд эхний ээлжийн зураг төслийг 2022 оны 5 дугаар сард, 2 дугаар ээлжийн зураг төслийн ажлыг 2022 оны 12 дугаар сард тус тус магадлалаар батлуулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сард Барилгын хөгжлийн төвөөс актаар хүлээн авсан.	70
1.4 “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг хэрэгжүүлэхээр туссан арга хэмжээний биелэлтийг хангах, төслүүдийн бэлтгэл ажлыг хангах				
1.4.1	Орон нутагт хэрэгжүүлэх төслүүдийн техникийн баримт бичгийн бүрдлийг хангах;	Орон нутагт хэрэгжүүлэх төслүүдийн архитектур төлөвлөлтийн даалгавар, зургийн даалгавар, техникийн нөхцөлүүд зэрэг баримт бичгийг бүрдүүлсэн байна.	Орон нутгийн төслүүд дээр өмнө нь хийгдэж, магадлалаар батлагдсан зураг төслийн архитектур төлөвлөлтийн даалгавар, магадлалын дүгнэлт, холбогдох шугам сүлжээний техникийн нөхцөл бүрдсэн бөгөөд төслийн барилга угсралтын ажил эхлэх үед шинэчилж авахаар төлөвлөсөн. Гүйцэтгэх захирлын 2023.01.23-ны өдрийн А/03 тушаалаар Сүхбаатар, Хэнтий, Сэлэнгэ аймгуудад байрлалтай дуусаагүй барилгуудын газруудыг тухайн орон нутагт шилжүүлэхэд шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, тухайн газар дээр хийгдсэн суурийн үнэлгээг гүйцэтгүүлж газрыг дахин үнэлүүлэх үүрэг бүхий ажлын	100

			хэсгийг байгуулж, ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг 2023 оны 1, 2 дугаар сард явуулж, гүйцэтгэгчээр “Арвижих Эстимейт” ХХК шалгарч, үнэлгээний ажлын тайланг 2023 оны 3 дугаар сард актаар хүлээлгэн өгсөн. Гүйцэтгэх захирлын 2023.03.20-ны өдрийн А/24 тушаалаар Нийслэлийн Баянзүрх, Багануур дүүрэг, Архангай, Ховд, Хэнтий, Хөвсгөл аймгуудад байрлах төслийн талбайд БОТБҮнэлгээ, БОННҮнэлгээ, ГТБЧХБаталгаа зэрэг судалгаа, шинжилгээний ажлуудыг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг нээлттэй сонгон шалгаруулж, гэрээ байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг 2023 оны 3, 4 дүгээр сард явуулж, гүйцэтгэгчээр “Лимитед Эко Протект” ХХК, “Үзмон” ХХК нар шалгарч, судалгааны ажлын тайланг боловсруулж дуусган, эрх бүхий байгууллагаар батлуулж, 2023 оны 10 дугаар сард актаар хүлээлгэн өгсөн.	
1.4.2	Аймаг, нийслэлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний хүрээнд орон сууцны хороолол барих боломжтой газрыг тодорхойлж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд Засаг дарга нартай хамтран ажиллах, холбогдох тооцоо, судалгааг боловсруулж, төслийн санал боловсруулах;	Орон нутгийн төр захиргааны байгууллагуудтай хамтран ажиллаж, хэрэгжүүлэх төслийн саналыг боловсруулсан байна. Уг саналыг олон улсын байгууллага, хувийн хэвшилд хүргүүлж төслийг эхлүүлэх холбогдох бэлтгэл ажил хангагдсан байна.	Гүйцэтгэх захирлын 2023.03.03-ны өдрийн А/16 болон А/17 дугаар тушаалаар Архангай, Ховд, Хэнтий, Сэлэнгэ, Сүхбаатар аймгуудад байрлах компанийн эзэмшлийн газар дээр шинээр хэрэгжүүлэх орон сууцны төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулагдаж, холбогдох ажлыг 2023.03.07-ны өдрөөс 2023.04.04-ний өдрийн хооронд зохион байгуулсан. Мөн Гүйцэтгэх захирлын 2023.06.26-ний өдрийн А/40, 2023.09.11-ний өдрийн А/52 тушаалуудаар Хөвсгөл аймгийн Мөрөн суманд хэрэгжүүлэх “480 айлын орон сууц”-ны төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах хуулийн этгээдийг нээлттэй сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг 2023 онд 3 удаа зохион байгуулсан. Бэлтгэл ажлыг бүрэн хангаж төслийн саналыг боловсруулсан.	100
1.5 “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн эзэмшилд байгаа Улаанбаатар хот болон хөдөө орон нутаг дахь газрын асуудлыг шийдвэрлэх бэлтгэл ажлын хүрээнд				
1.5.1	Компанийн нэр дээр байгаа газруудын төлбөрийг төлж, тооцоо нийлсэн акт авах;	2023 онд 20 газрын 276,755,057 төгрөгийн төлбөрийг төлж,	Компанийн нэр дээр бүртгэлтэй газруудын 2023 оны газрын төлбөрийг төлж тооцоо нийлсэн акт авсан. Газрын төлбөрт нийт 427,9 сая төгрөгийг төлсөн.	100

		тооцоо нийлсэн акт авсан байна.		
1.5.2	Монгол Улсын Хөгжлийн банкны барьцаанд байгаа "Солонго-1" орон сууцны хорооллын 18.8 га барилгажих талбайн газрыг чөлөөлж, цахимд шилжүүлж, улсын бүртгэлийн дугаар авах;	Монгол Улсын Хөгжлийн банкны барьцаанаас "Солонго-1" орон сууцны хорооллын 18.8 га барилгажих талбайн газрыг чөлөөлсний дараа цахимд шилжүүлж улсын бүртгэлийн дугаар авсан байна.	"Буянт-Ухаа 2" хорооллын 28,8 га газраас "Солонго-1" төслийн 13.6 га газрыг тусад нь салгах ажлыг 2023 оны 8 дугаар сард зохион байгуулж, НЗД-ын 2023.08.23-ны өдрийн А/954 дугаар тушаалаар газрыг цахим бүртгэлийн системд бүртгүүлэн улсын бүртгэлийн Э дугаар авсан.	100
ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ				
2.1 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд төрийн өмчийн түрээсийн орон сууцыг түрээслүүлэх, өмчлүүлэх ажлыг нийслэл болон орон нутагт зохион байгуулах				
2.1.1	Нийслэл болон орон нутгийн түрээслэгч иргэдтэй "Төрийн түрээсийн орон сууцад орон сууц түрээслүүлэх гэрээ"-г сунгах ажлыг зохион байгуулах;	Хүсэлт хүргүүлсэн иргэдтэй түрээсийн гэрээний сунгалтыг хийж, гэрээ байгуулсан байна.	"Төрийн түрээсийн орон сууцад орон сууц түрээслүүлэх гэрээ"-ний сунгалт хийх хүсэлт ирүүлсэн иргэдийн гэрээний сунгалтыг тухай бүр хэрэгжүүлж байна.	100
2.1.2	Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журмын хүрээнд хүсэлт хүргүүлсэн иргэдтэй "Төрийн түрээсийн орон сууцыг өмчлөх гэрээ" байгуулах;	Хүсэлт хүргүүлсэн иргэдтэй түрээслээд өмчлөх гэрээ байгуулсан байна.	"Төрийн түрээсийн орон сууцыг өмчлөх гэрээ" байгуулах хүсэлт ирүүлсэн 61 иргэнтэй түрээслээд өмчлөх гэрээ байгуулсан.	100
2.1.3	"Төрийн түрээсийн орон сууцад орон сууц түрээслүүлэх гэрээ" байгуулсан иргэдийн түрээсийн төлбөрийг хугацаанд нь төвлөрүүлэх;	Эхний хагас жилд: 700 сая төгрөг Жилийн эцэст: 1.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.	"Төрийн түрээсийн орон сууцад орон сууц түрээслүүлэх гэрээ"-ний дагуу нийт 1,862,806,200 төгрөгийн орлого төвлөрүүлэхээс, эхний хагас жилд 990,811,435 төгрөгийн орлого төвлөрүүлж, жилийн эцэст 2,030,094,617 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.	100
2.1.4	"Төрийн түрээсийн орон сууцыг өмчлөх гэрээ" байгуулсан иргэдийн түрээсийн төлбөрийг хугацаанд нь төвлөрүүлэх;	Эхний хагас жилд: 2.2 тэрбум төгрөг Жилийн эцэст: 4.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.	"Төрийн түрээсийн орон сууцыг өмчлөх гэрээ"-ний дагуу нийт 4,540,777,841 төгрөгийн орлого төвлөрүүлэхээс эхний хагас жилд 2,347,479,659 төгрөгийн орлого төвлөрүүлж, жилийн эцэст 4,700,177,683 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.	100
2.1.5	"Төрийн түрээсийн орон сууцад орон сууц түрээслүүлэх гэрээ"-ний хэрэгжилтэд хяналт тавих, ажлын хэсэг байгуулан хяналт шалгалт хийж, тайланг нэгтгэх, гэрээний үүргээ зөрчсөн иргэдэд	Жилийн эцэст: Гэрээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, өнгөрсөн оны дүнгээс өсгөсөн байна.	Хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулан Сэлэнгэ, Дархан-Уул, Хэнтий, Архангай аймгуудад албан томилолтоор ажилласан ба Улаанбаатар хотын "Буянт-Ухаа 2" болон "Хангай" хотхонд нийт 1302 орон сууцад шалгалт хийснээс гэрээний үүрэг зөрчсөн 25 түрээслэгчид мэдэгдэл, шаардлага хүргүүлж зөрчлийг бүрэн	100

	журмын дагуу арга хэмжээ авч ажиллах;		арилгуулсан. Мөн төлбөр барагдуулах гэрээний үүргээ зөрчсөн 361 иргэнд журмын дагуу арга хэмжээ авч 279 иргэний 262,523,100 төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулан 78 иргэнд төлбөр барагдуулах тухай болон гэрээ цуцлах тухай мэдэгдэл өгсөн байна. Түрээсийн мэргэжилтнүүдэд болон орон нутаг, УБ хот дахь гэрээт ажилтнуудад сар бүрийн 05-ны дотор төлбөрийн үлдэгдэлтэй айл, өрхүүдийн нэхэмжлэхийг гарган хүргүүлж, төлбөрийн үлдэгдэл өндөртэй иргэдэд утсаар болон биечлэн шаардлага хүргүүлж, хяналт тавьж ажилласан.	
2.1.6	“Түрээсийн орон сууцны журам”-ыг шинэчлэх ажилд санал өгч, Барилга хот байгуулалтын яамтай хамтран ажиллах;	Жилийн эцэст: Журам шинэчлэх ажилд хамтран оролцож, журамд санал өгсөн байна.	Түрээсийн журамд шинээр оруулах саналыг БХБЯ-руу 2023.05.11-ний өдөр 1/551 тоот албан бичгээр боловсруулан хүргүүлсэн.	100
<i>2.2 Нийслэл болон орон нутагт баригдсан орон сууц, авто зогсоол, зоорины давхар, агуулах, үйлчилгээний төвийн суурийг худалдан борлуулах, борлуулалтын орлогыг төвлөрүүлэх</i>				
2.2.1	“Буянт Ухаа-1”, “Буянт Ухаа-2” хорооллын авто зогсоолын борлуулалтын орлогыг төвлөрүүлэх;	Жилийн эцэст: Үлдэгдэл авто зогсоолын төлбөр болох 380,092,000 төгрөгийг төвлөрүүлнэ.	Тайлант хугацаанд нийт 487,496,490 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.	100
2.2.2	“Буянт Ухаа-2” хорооллын худалдан борлуулсан орон сууц, үйлчилгээний төвийн суурь барилга, агуулах, зоорины давхрын борлуулалтын орлогыг төвлөрүүлэх;	Жилийн эцэст: Үйлчилгээний төвийн суурь 256,500,000 төгрөгийг төвлөрүүлэх асуудлаар худалдах, худалдан авах гэрээ байгуулсан “Эрдэнэт Төгөл” ХХК-тай гэрээний шинэчлэлт хийсэн байна. Зоорины давхрын үлдэгдэл 63,878,100 төгрөг төвлөрүүлнэ.	“Эрдэнэт Төгөл” ХХК 256.5 сая.төг үлдэгдэл төлбөрт 74м2 оффисын зориулалттай талбай санал болгож ТУЗ-ын хурлаар хэлэлцүүлж, ТӨБЗГ-аас зөвшөөрөл авахаар болсон. “Буянт Ухаа-2” хорооллын 1001-р орон сууцны зоорины давхрын төлбөрийн үлдэгдэл болох 63,000,000 төгрөг, 1013-р орон сууцны зоорины давхрын үлдэгдэл 878,100 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн.	70
2.2.3	“40 000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд баригдсан орон сууц, зоорины давхрын борлуулалтын үлдэгдэл орлогыг төвлөрүүлэх;	Жилийн эцэст: Зоорины давхруудаас 28,039,728 төгрөг, орон сууцуудаас 14,465,000 төгрөгийг тус тус	Төв аймгийн 30 айлын орон сууцны зоорины давхрыг худалдах, худалдан авах гэрээгээр 2 иргэн борлуулсан бөгөөд график төлөлтийн дагуу нийт 52,908,292 төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Хэнтий аймгийн Бор-Өндөр суман дахь 20 айлын орон сууцны 52	90

		төвлөрүүлнэ. Нийт 42,504,728 төгрөг болно.	тоотын худалдах, худалдан авах гэрээгээр борлуулсны үлдэгдэл төлбөр болох 34,465,000 төгрөгийг төвлөрүүлсэн. Хэнтий аймгийн “30 айл”-ын орон сууцны дор байрлах зоорины давхрыг худалдан борлуулахаар “Хэнтий аймгийн хамгийн том зар”, “Хэнтий зар”, “Хэнтий Чингис хот” зэрэг Facebook зар, мэдээллийн хуудаст 6 удаа худалдан борлуулах зар тавьж ажилласан. Уг зоорины давхар нь бохир алддаг гэдэг шалтгаанаар иргэд худалдан авах сонирхолгүй байсан.	
2.2.4	Дорнод аймгийн “Залуус хороолол”-ын амины орон сууцны борлуулалтын орлогыг төвлөрүүлэх;	Жилийн эцэст: Төлөвлөгөөт орлого 150,000,000 төгрөг төвлөрүүлнэ.	Тайлант хугацаанд Дорнод аймагт 2 удаагийн томилолтоор ажиллаж 275,824,000 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.	100
2.2.5	“1000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд баригдсан орон сууц болон авто зогсоолын борлуулалтын орлогыг төвлөрүүлэх;	Жилийн эцэст: Хэнтий, Ховд аймгийн 120 айлын орон сууцны доорх авто зогсоол буюу үлдэгдэл орлого 33,521,100 төгрөг төвлөрүүлнэ.	Хэнтий, Ховд аймгийн 120 айлын орон сууцны авто зогсоолуудаас нийт 51,494,670 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Хэнтий аймаг дахь “Шинэ-Өндөрхаан” орон сууцны хорооллын доор байрлах 1-19 тоот, 2-19 тоот дугаартай авто зогсоолуудын төлбөр төлөгдөхгүй байсан тул иргэдтэй байгуулсан гэрээг цуцлан 2024 онд дуудлага худалдаагаар борлуулахаар шийдвэрлэсэн.	70
<i>2.3. Нийслэл болон орон нутагт баригдсан орон сууц, авто зогсоол, зоорийн давхрын барилгын ашиглалтын үйл ажиллагааг холбогдох байгууллагад хүлээлгэн өгөх, ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэх</i>				
2.3.1	Түрээсийн орон сууцны ашиглалтын хэвийн үйл ажиллагаа хангахад ашиглалт хариуцсан мэргэжлийн байгууллагатай хамтран шийдвэрлэж, иргэдийн гомдлыг барагдуулж ажиллах;	Түрээсийн орон сууцны ашиглалтын талаар иргэдээс ирүүлсэн гомдлыг барагдуулж ажилласан байна.	Хэнтий аймгийн Шинэ-Өндөрхаан хороолол, 30 айлын орон сууц, Сэлэнгэ аймгийн Ширхэнцэг мандал хорооллын ашиглалтын асуудлаар тухай бүр холбогдох СӨХ-тэй хамтран ажиллаж, бусад түрээсийн орон сууцны ашиглалтын талаар ирүүлсэн гомдлыг тухай бүр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж шийдвэрлэсэн. “Буянт-Ухаа 2” хорооллын 1022 дугаар орон сууцны доод зоорины давхрын хөрсний ус нэвчилтийг гэрээт ажилтнаар соруулах ажлыг гүйцэтгүүлж ажиллав.	100
<i>2.4 Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ гаргуулах, барьцаа хөрөнгө чөлөөлүүлэх арга хэмжээ авах</i>				
2.4.1	Хөгжлийн банкны зээлийн барьцаанд байгаа нийслэл болон орон нутагт баригдсан орон сууцны үл хөдлөх эд хөрөнгийг чөлөөлөх талаар арга хэмжээ авах;	Нийслэл, орон нутаг дахь Орон сууц 109, автозогсоол-112 барьцаанаас чөлөөлж, иргэдийн нэр дээр гэрчилгээ	Буянт-Ухаа 2” хорооллын автозогсоол 48, орон сууцны гэрчилгээ гаргуулах 6 иргэнд бичиг баримтыг хүлээлгэн өгсөн. Архангай аймгийн “Булганхангай” хорооллын 27 автозогсоол, Дархан-Уул аймгийн “Нархан хотхон” хорооллын 4 орон сууц, Сэлэнгэ	100

		гаргуулах баримт, бичгийг иргэн бүр дээр бүрдүүлж өгнө.	аймгийн “Ширхэнцэг мандал” хорооллын 1 орон сууц, Увс аймгийн “Галданбошиг” хорооллын 19 автозогсоолуудыг барьцаанаас чөлөөлж, иргэдийн нэр дээр гэрчилгээ гаргуулахад шаардлагатай албан бичиг, бусад холбогдох материалуудыг бүрдүүлэн иргэдэд хүлээлгэн өгсөн. Нийт 14 нэр төрлийн 265 үл хөдлөх эд хөрөнгийг барьцаанаас чөлөөлж, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг гаргуулах ажлыг зохион байгуулсан.	
2.4.2	Иргэдийн худалдан авсан банкны барьцаанд тавигдаагүй үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг гаргуулах;	Гэрчилгээ гаргуулахаар хүсэлтээ ирүүлсэн иргэдийн нэр дээр гэрчилгээ гаргуулах баримт, бичгийг иргэн бүр дээр бүрдүүлж өгнө.	Тайлант хугацаанд гэрчилгээ гаргуулахаар хүсэлтээ ирүүлсэн “Буянт-Ухаа” 1, 2 хорооллын 57 иргэнд, орон нутгийн 41 иргэнд, нийт 98 иргэний нэр дээр гэрчилгээ гаргуулах албан бичиг болон бусад холбогдох материалын бүрдлийг хангаж иргэн тус бүрд хүлээлгэн өгсөн.	100
2.5 Аж ахуйн нэгж байгууллага болон иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэх				
2.5.1	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллана.	Жилийн эцэст : Санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Тайлант хугацаанд 253 өргөдөл гомдол ирснээс 224 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу хүргүүлсэн ба 9 өргөдөл шийдвэрлэх шатанд байна. Хагас жилийн байдлаарх БХБЯ-нд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг 93.9%-тай тайлагнан ажилласан.	90
ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД КОМПАНИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ				
3.1 Хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны гэрээтэй байгууллагуудаас авах авлагыг барагдуулах				
3.1.1	“Ти Ти энд Би” ХХК-ийн төлбөрийг хуваарийн дагуу төлүүлэх;	Нийт 6.3 сая төгрөгийг төлж, нийт өр төлбөр дуусна.	Ти Ти энд Би” ХХК нь 2023 онд нийт 6,399,458 төгрөгийг төлсөн. Үүнээс үндсэн авлага 6,318,983.32, хүү 80,474.68 төгрөг.	100
3.2 Компани авлигын эсрэг үйл ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлэх				
3.2.1	Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд бөглүүлэн ТӨБЗГ болон АТГ-т хүргүүлэх;	Жилийн эцэст: Холбогдох албан тушаалтнуудыг ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд тайлагнах, “Авлигаас урьдчилан сэргийлэх” чиглэлээр сургалтад хамруулсан байна.	Тайлант хугацаанд газар хэлтсийн дарга нар, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг нийт 14 албан тушаалтан хуулийн хугацаанд ХАСХОМ-ээ мэдүүлсэн. ХАСХОМ-1 тайланг хуулийн хугацаанд гарган 2023.03.24-ний өдрийн 1/397 дугаартай албан бичгээр ТӨБЗГ-т хүргүүлсэн.	100
3.2.2	Компанийн “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023	Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдийг	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт	70

	оны төлөвлөгөө"-г боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх;	бүрэн хэрэгжүүлж ажиллана.	зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (facebook, twitter), мэдээллийн самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэж байна. Мөн АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг компанийн хэмжээнд зохион байгуулж, аянд нэгдэх, уриалга гаргах зэргээр ажиллаж байна. Компанийн цахим сайтад авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" баннерыг байршуулсан.	
3.3 Компанийн 2022 оны худалдан авах ажиллагааны тайлан, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Сангийн яаманд хүргүүлэх				
3.3.1	Компанийн 2022 оны худалдан авах ажиллагааны тайлан, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Сангийн яаманд хүргүүлэх	Компанийн 2022 оны худалдан авах ажиллагааг тайлагнаж, 2023 оны худалдан авалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна.	Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулан 2022/12/28-ны өдрийн 1/1035 дугаар албан бичгээр, 2022 оны худалдан авах ажиллагааны тайланг 2023/01/16-ны өдрийн 1/72 дугаар албан бичгээр тус тус ТӨБЗГ-т хүргүүлсэн.	100
3.4 Шүүхийн шийдвэр эцэслэн гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр хийгдэж байгаа гүйцэтгэх ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд явагдаж байгаа эсэхэд хяналт тавих, хуулийн хүрээнд шийдвэрлүүлэх				
3.4.1	Шүүхийн шийдвэр эцэслэн гарч шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр 4 хуулийн этгээд, 2 иргэнтэй холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь холбогдох хууль, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах;	"Могоул скай" ХХК-иас 4.123.125.726 төгрөгийг, "Улсын ерөнхий прокурорын газар"-аас 144,677,129 төгрөгийг, "Хэнтий аймгийн засаг даргын тамгын газар"-иас 1,670,167,536 төгрөгийг, "Үндэсний барилга консерциум" ХХК-иас 1,152,633,333 төгрөгийн төлбөрийг тус тус гаргуулах хуваарь тогтоож тохиролцоонд хүрсэн байна.	1. "Жи Ди" ХХК нь үлдэгдэл төлбөр болох 429,223,950 төгрөгийн өглөгтөө Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо, 20 дугаар гудамж, 352/Б тоот 700 м.кв газрыг манай өмчлөлд шилжүүлэх санал гаргасан боловч ТУЗ-ийн 2 удаагийн хурлаар хүлээн авахаас татгалзсан. 2. "Могоул скай" ХХК нь өр төлбөрт барьцаалагдсан орон сууцтай холбогдуулан "Анхны албадан дуудлага худалдаа явуулах тухай тогтоолыг хүчингүй болгуулах" шаардлага бүхий нэхэмжлэлийг СБДИХАШШ-д гаргасан. Анхан шатны шүүх болон НИХДЗШШүүх тус тус тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн бөгөөд УДШ хэргийг хүлээн авч хэлэлцэхээс татгалзсан. 3. "Шинэ мянганы констракшн" ХХК-иас 1,657,933,333 төгрөгийг гаргуулах ШШГА-нд манай компанийн өмнө төлбөр авах 6 иргэн байна. ХУД-ийн 5-р хороо, үйлдвэрийн баруун бүс, эрчим	70

			<p>хүчний гудамж 451 тоот хаягт байрлалтай 1088 м.кв талбайтай 80 хувийн гүйцэтгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийг дарааллын дагуу төлбөр авагч нарт санал болгож байна.</p> <p>Г. УЕПГ нь 189,677,123 төгрөгийн өр төлбөрөөс 75,000,000 төгрөг төлсөн байна.</p> <p>4. “Хэнтий аймгийн засаг даргын тамгын газар”-аас 1,670,167,536 төгрөгийн өр төлбөрийг барагдуулахаар төлбөрийн хуваарь гаргаж 2023.09.18-ны өдрийн 23/1-15 дугаартай “Өр төлбөр барагдуулах” гэрээ байгуулсан.</p> <p>5. Иргэн Д.Дэлгэрмаа нь 6,850,000 төгрөгийн өр төлбөрөөс 1,650,000 төгрөгийг төлсөн байна.</p>	
<p><i>3.5 Компанийн эрх ашгийг болон мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалж, шүүх, хуулийн байгууллагад итгэмжлэлээр оролцох, иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдол, нэхэмжлэлийн дагуу компанийг төлөөлөх, хэргийг шийдвэрлүүлэх</i></p>				
3.5.1	<p>Шүүхийн шатанд хянагдаж буй 4 иргэн, 3 хуулийн этгээдтэй холбогдох хэрэгт байгууллагыг төлөөлөх, шүүхээр хэргийг эцэслэн шийдвэрлүүлэх ажиллагааг эрчимжүүлэх.</p>	<p>Бүх хэрэг, маргаанд компанийн эрх ашгийг хамгаалж төлөөлөгчөөр оролцсон байна.</p>	<p>Тайлант хугацаанд иргэний журмаар “Үндэсний бүтээн байгуулалтын корпораци” ХХК, “Могоул скай” ХХК, “Мөнхийн ундраа увс” ХХК, “Баянгийн говь” ХХК зэрэг хуулийн этгээдүүдийн нэхэмжлэл бүхий нийт 4 хэрэгт, иргэн О.Мөнхтуяа, У.Насанчимэг, У.Ундармаа, А.Ундармаа, Э.Эрдэнэхүү, Н.Энхбат, Н.Лувсандорж, Ж.Бямбагэрэл, Р.Уранчимэг нарын нэхэмжлэл бүхий иргэний 7, захиргааны 2 хэрэгт компанийг эрх ашгийг хамгаалан шүүхэд төлөөлөн ажилласан.</p>	100
3.5.2	<p>Цагдаагийн байгууллага дээр шалгагдаж байгаа нэр бүхий 1 аж ахуйн нэгж, 2 иргэнтэй холбогдох нийт 3 хэрэгт байгууллагыг төлөөлөх, эцэслэн шийдвэрлүүлэх ажиллагааг эрчимжүүлэх</p>	<p>Бүх хэрэг, маргаанд компанийн эрх ашгийг хамгаалж төлөөлөгчөөр оролцсон байна.</p>	<p>1. Иргэн П.Ганзориг-т холбогдох хэргийг 2023/01/19-ний өдөр БЗДЭХАШШ-ээс П.Ганзоригийг залилах гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, 13,055,000 төгрөгийн торгох ялаар шийтгэсэн.</p> <p>2. Иргэн У.Насанчимэг нь манай байгууллагад “Борлуулалтын мэргэжилтэн” албан тушаалыг эрхэлж байхдаа үл таних этгээдүүдийн хамт орон сууц худалдан авагч нарын 10 ширхэг И-Баримтыг өөрийн татварын цахим системд зөвшөөрөлгүй, хууль бусаар бүртгүүлсэн нь уг ажилтны хууль бус үйлдлийн улмаас хохирсон иргэдийн өргөдөл гомдлоор илэрснээр тус ажилтныг Гүйцэтгэх захирлын 2022/12/14-ний өдрийн Б/93 дугаар тушаалаар үүрэгт ажлаас нь чөлөөлж, ЧД-ийн цагдаагийн 1 дүгээр хэлтэст 2022/12/14-ний өдрийн 1/994 дугаар албан бичгээр гомдол гаргаснаар</p>	100

			<p>хэрэг бүртгэлийн ажиллагаа үргэлжилж байна.</p> <p>3. Э.Бат-үүл, А.Гантулга нарт холбогдох эрүүгийн хэргийг НЭХДЗШШ-ээс 2022/04/04-ний өдөр мөрдөн шалгах ажиллагаа дутуу хийгдсэн үндэслэлээр хэргийг АТГ руу мөрдөн байцаалтын шатанд буцааж хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байна.</p> <p>4. Б.Сайнжаргал нь байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 ширхэг зөөврийн компьютерийг эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр, дур мэдэн авч явсан. Уг асуудалд холбогдуулан ЧД дэх цагдаагийн I дүгээр хэлтэст 2023.09.12-ны өдрийн 1/858 дугаар албан бичгээр гомдол гаргаснаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээн мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байна.</p>	
3.5.3	Мэдээллийн аюулгүй байдлын харилцааг зохицуулсан журмын төсөл боловсруулж, хэрэгжилтийг хангуулах	Шаардлагатай журмын төслийг боловсруулж батлуулсан байна.	Гүйцэтгэх захирлын А/63 тоот тушаалаар "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам"-ыг баталгаажуулсан.	100
3.6 Аж ахуйн нэгж байгууллага, иргэнтэй байгуулах гэрээний төслийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах				
3.6.1	Компаниас хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд болон дотоод үйл ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний төслийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих	Шаардлагатай гэрээний төслийг боловсруулж батлуулсан байна.	Тайлант хугацаанд нийт 10 гэрээний төсөл боловсруулж, 9 гэрээний төслийг хянаж, санал оруулсан байна. Компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөх зорилгоор Ёс зүйн зөвлөлийн болон Мэдээллийн аюулгүй байдлын журмыг тус тус боловсруулан удирдлагад танилцуулж батлуулсан.	100
ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. КОМПАНИЙН САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ				
4.1 Компанийн 2024 оны төлөвлөлтийг гаргаж, нэгтгэн боловсруулж Барилга, хот байгуулалтын яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, бусад шаардлагатай дээд байгууллагуудад шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах				
4.1.1	Компанийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулан ТУЗ-өөр хэлэлцүүлж, ТӨБЗГ-аар батлуулах	Жилийн эцэст: 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна	1. Компанийн 2024-2026 оны Зорилтын саналыг тоон үзүүлэлтээр болон бичгээр тайлбарын хамт гарган 2023.02.17-ны өдрийн 1/334 дугаартай албан бичиг, 2023.04.24-ний өдрийн 1/522 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн. 2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023.11.21-ний өдрийн хурлаар 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний	100

			төслийг хэлэлцүүлэн 14 дугаартай ТУЗ-ийн тогтоол гарсан. Гүйцэтгэх захирлын 2023.11.21-ний 1/1088 дугаартай албан бичгээр 2024 оны төлөвлөгөөний төслийг, танилцуулгын хамт ТӨБЗГ-ын хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн. /Хугацаа: 2023.12.15-ны өдөр/	
4.2 Хөгжлийн банк болон улсын төсвөөс авсан зээл, зээлийн хүүгийн төлбөрийг төлөх				
4.2.1	Хөгжлийн банканд худалдсан үнэт цаасны эргэн төлөлтийг хуваарийн дагуу төвлөрүүлэх	14.6 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдөнө.	Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээний 3.2.11-д заасны дагуу зээлийн хүүгийн төлбөрийг хагас жил тутамд төлөх ба эхний хагас жилийн төлбөрт 2023.06.16-ны өдөр 7,650,232,876.71 төгрөгийг Хөгжлийн банканд төлсөн. Сүүлийн хагас жилийн төлбөрт 7,608,198,630.14 төгрөгийг 2023.12.17-нд төлөхөөр харилцах дансанд байршуулаад байна.	100
4.2.2	“Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт тоног төхөөрөмж”-ийг цаашид эзэмших байгууллагын баланст шилжүүлэх ажлыг Хөгжлийн банкны хамтарсан ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулах	“Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт тоног төхөөрөмж”-ийг цаашид эзэмших байгууллагын баланст шилжүүлсэн байна.	Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын хүрээнд Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, МУХБ-ны хамтарсан ажлын хэсэг байгуулагдан, тоног төхөөрөмжийн зээлд авах арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Батлан хамгаалахын сайдын 2023.05.02-ны өдрийн 1а/1662 дугаартай албан бичгээр санал авахаар БХБЯ-нд ирүүлсэн. Уг тогтоолын төслийг дэмжсэн хариуг 2023.05.09-ний өдрийн 1/1697 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд БХБЯ, ХХАХҮЯ, ГЕГ, Хөгжлийн банк зэрэг холбогдох газруудад хандаж, уулзалт зохион байгуулан ажиллаж байна. Гүйцэтгэх захирлын 2023.11.23-ны өдрийн 1/1125 дугаартай албан бичгээр Хөгжлийн банканд, Барилга, хот байгуулалтын сайдын 2023.11.06-ны өдрийн 1/4018 дугаартай албан бичгээр Батлан хамгаалахын сайдад тус тус дээрх тогтоолын хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллах талаар хүсэлтээ хүргүүлсэн.	50
4.3 “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний хэрэгжилтийг хангуулах				
4.3.1	БХБЯ-тай байгуулсан “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний 2019, 2020, 2021, 2022 оны нийт 18,2 тэрбум төгрөгийн гэрээний дагуух эргэн төлөлтийг	2023 онд 1,200.0 сая төгрөгийг хуваарийн дагуу төлнө.	Дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу нийт 1,200,000,000 төгрөгийг хугацаанд нь төлсөн. 1. 2020 оны гэрээний хуваарьт төлбөр 300,0 сая төгрөгийг 2023.01.05-нд	100

	“Төрийн өмчийн түрээсийн орон сууцыг түрээслээд өмчлөх” гэрээ байгуулсан иргэдийн төлсөн орлогоос хуваарийн дагуу төлөх		2. 2021 оны гэрээний хуваарьт төлбөр 300,0 сая төгрөгийг 2023.07.17-нд 3. 2019 оны гэрээний хуваарьт төлбөр 300,0 сая төгрөгийг 2023.09.27-нд тус тус төлсөн. Мөн 2022 оны гэрээний хуваарьт төлбөр 300,0 сая төгрөгийг 2023.12.10-нд төлөхөөр хүлээгдэж байна. Дамжуулан зээлдүүлэх гэрээний нийт үлдэгдэл 2023.11.25-ны байдлаар 22,3 тэрбум төгрөг, нийт эргэн төлөлт 2,7 тэрбум төгрөг.	
4.4 2024 оны улсын төсөвт хөрөнгө суулгах төсвийн саналыг бэлтгэх, татан төвлөрүүлэх, эргэн төвлөрүүлэх				
4.4.1	Тухайн жилийн улсын төсөвт суулгах төсвийн саналыг боловсруулж БХБЯ-нд хүргүүлэх	Хэрэгжүүлж буй төслүүдийн дэд бүтцэд шаардагдах хөрөнгө болон Засгийн газрын 2016 оны 38, 169 дүгээр тогтоолын дагуу түрээсийн орон сууцны үнийг 2024 оны улсын төсөвт суулгах саналыг боловсруулж БХБЯ-д хүргүүлсэн байна	Төслийн хэрэгжилт, хяналтын хэлтэстэй хамтран “Залуус-1”, “Солонго 1, 2”, “Эко яармаг” төслүүдийн дэд бүтцэд шаардагдах хөрөнгө болон Засгийн газрын 2016 оны 38, 169 дүгээр тогтоолын дагуу түрээсийн орон сууцны үнийн үлдэгдэл болох 57,3 тэрбум төгрөгийг төсөвт суулгах саналыг боловсруулж 2023.08.07-ны өдрийн 1/778 дугаартай албан бичгээр БХБЯ-нд хүргүүлж 5,0 тэрбум төгрөгийг тусгуулсан.	100
4.4.2	Төсөвт хөрөнгийг суусан татан төвлөрүүлэх, холбогдох санхүүжилтэд хяналт тавих	Төсөвт суусан хөрөнгийг БХБЯ-тай “Дамжуулан зээлдүүлэх” гэрээ байгуулж, үнэт цаасны төлбөртөө суусан хөрөнгийг татан авсан байна.	Барилга, хот байгуулалтын яамтай 2023.08.07-ны өдрийн 2023/261 дугаартай Дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулж, тус гэрээний дагуу 2023.09.20-ны өдөр 5,0 тэрбум төгрөгийг Хөгжлийн банкны данс руу шилжүүлэн авсан.	100
4.5 Компанийн санхүүгийн тайлан, баланс гаргах, бараа ажил үйлчилгээ худалдан авах, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих				
4.5.1	Санхүүгийн тайлан баланс гаргах	Жилийн эцэст: Төрийн сангийн аж ахуй нэгжийн тайлан, төрийн өмчит Компанийн тайланг гарган БХБЯ, ТӨБЗГ, Төрийн санд цаасаар болон цахимаар хүргүүлнэ.	Тайлант оны 1-3-р улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж, ТӨБЗГ, Сангийн яам, Үндэсний аудитын газар, Нийслэлийн санхүү төрийн сангийн газарт тус тус цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлж ажилласан.	100
4.5.2	“Солонго 1, 2” төслийн санхүүгийн тайлан баланс гаргах	Жилийн эцэст: Төрийн сангийн аж ахуй нэгжийн тайлан, төрийн өмчит Компанийн тайланг гарган БХБЯ, ТӨБЗГ,	Төрийн сангийн аж ахуй нэгжийн тайлан, төрийн өмчит Компанийн тайланг гарган БХБЯ, ТӨБЗГ, Сангийн яаманд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлсэн.	100

		Төрийн санд цаасаар болон цахимаар хүргүүлнэ.		
4.5.3	Компанийн хэмжээнд үндсэн хөрөнгийн худалдан авалтын зохион байгуулах, нягтлан бодох бүртгэлийг хийх	Жилийн эцэст Төрийн хэмнэлтийн тухайн хуулийн хүрээнд 166,1 сая хүртэлх төгрөгийн үндсэн худалдан авалтыг хийж, санхүүгийн программд зохих нягтлан бодох бүртгэлийг хийсэн байна.	Компанийн хэмжээнд 24,384,030 төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалтыг хийж, санхүүгийн программд үндсэн хөрөнгийн дансанд 100 хувь бүртгэсэн. Гүйцэтгэх захирлын 2023.08.29-ны өдрийн А/50 дугаартай үнэлгээний хороог байгуулж, 137,0 сая төгрөгийн үнэ бүхий компьютер, техник хэрэгсэл худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.	100
4.5.4	Компанийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, тооллого хийх, ашиглалтын хугацаа дууссан хөрөнгө актлах, дахин үнэлэх	Эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж, зохих нягтлан бодох бүртгэлийг хийсэн байна.	ТӨБЗГ-ын 2023 оны 461 дугаартай тогтоолын дагуу ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 84 нэрийн, нийт 193'481'096.92 төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг акталж, данснаас хассан ба 448 дугаартай тогтоолын дагуу 76 нэрийн, нийт 56'553'841.82 төгрөгийн балансийн үнэ бүхий хөрөнгийг 14'583'212.18 төгрөгөөр дахин үнэлж бүртгэсэн.	100
4.5.5	Санхүүгийн тайланд аудит хийлгэх, аудитаас өгсөн санал зөвлөмжийг хэрэгжүүлэх	Санхүүгийн аудитын тайлангийн зөрчлийн тоо багассан байх.	Санхүүгийн тайлангийн "2022 оны аудитаар нийт 11 асуудлаар албан шаардлага-6, зөвлөмж-2, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн-2 төлбөрийн акт-1 өгөгдсөн. Нийт өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Гүйцэтгэх захирлын 2023.06.09-ны өдрийн А/36 дугаартай тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж, аудитын 2022 оны зөвлөмжийн биелэлтийг ТӨБЗГ-т 2023.10.24-ний өдрийн 1/1023 тоот албан бичгээр хүргүүлсэн.	100
4.6 Компанийн үйл ажиллагаа, шилэн дансны ил тод байдлыг ханган ажиллах				
4.6.1	Компанийн үйл ажиллагаа, шилэн дансны ил тод байдлыг ханган ажиллана.	Байгууллагын үйл ажиллагаа, шилэн дансны ил тод байдал хангагдсан байна.	Шилэн дансанд 13,276,106,939.67 төгрөгийн орлого, 17,000,957,365 төгрөгийн зарлагын гүйлгээг хуулийн хугацаанд шивж оруулсан. Тайлант хугацаанд шилэн дансанд 148 мэдээлэхээс 19 мэдээлэл оруулах хуулийн хугацаа болоогүй байна.	100
4.7 Компанийн дотоод үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах				
	Компанийн хэмжээнд дотоод үйл ажиллагаа болон санхүүгийн	Жилийн эцэст: Хяналт шалгалтын	Компанийн 2023 онд хийгдэх хяналт шалгалтын төлөвлөгөөг	

4.7.1	хяналт шалгалтыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх санал боловсруулан шийдвэрлүүлэх	төлөвлөгөө боловсруулан батлуулж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн байна.	2023.01.04-ний өдөр боловсруулан, гүйцэтгэх захирлаар батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу: 1.Гүйцэтгэх захирлын 2023.01.10-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал тогтоосон тушаал шийдвэрийг нягтлан шалгах хяналт шалгалтыг хийж, тайлан зөвлөмж боловсруулсан. Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн аудитын хороонд танилцуулан илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар ажиллаж байна. 2.Гүйцэтгэх захирал 2023 оны 5 сард өөрчлөгдсөн тул төлөвлөгөөт бусаар 2023.05.22 өдрийн баталсан удирдамжийн дагуу байгууллагын архив, бичиг хэргийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн.	70
<i>4.8 Компанийн хэтийн болон дунд хугацааны хөтөлбөр, жилийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг тайлагнах, холбогдох тайлан мэдээг хугацаанд нь гаргаж дээд шатны байгууллагад хүргүүлэх</i>				
4.8.1	Компанийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хагас жил, жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг боловсруулан батлуулж, БХБЯ-д хүргүүлэх	Компанийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хагас бүтэн жилийн гүйцэтгэлийн тайланг боловсруулан батлуулж БХБЯ-нд хүргүүлсэн байна	Компанийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг БХБЯ-аар батлуулсан. Тайлант оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг 88,4 % үнэлгээ авсан. Бүтэн жилийн тайланг 2023.12.08-ны өдрийн дотор БХБЯ-нд хүргүүлнэ.	100
4.8.2	Гүйцэтгэх захирлын 2022 оны "Контрактын гэрээ"-ний биелэлтийг гаргаж ТӨБЗГ-т хүргүүлэх	Гүйцэтгэх захирлын 2022 оны "Контрактын гэрээ"-ний биелэлтийг гаргаж ТӨБЗГ-аар дүгнүүлсэн байна	Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон контрактын биелэлтийн холбогдох материалыг ТӨБЗГ-т хүргүүлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023/03/30-ны 05 дугаартай тогтоолоор "ХАНГАЛТТАЙ" гэж дүгнэсэн.	100
<i>4.9 Компанийн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөрийн харилцааг зохицуулах</i>				
4.9.1	Компанийн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж ажиллах, ажил олгогч ажилтны хооронд үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулна.	Байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, ажлын байрны сул орон тоон дээр нээлттэй сонгон шалгаруулалт хийж, хүний нөөцийг бүрдүүлэн ажилласан байна	Тайлант хугацаанд хүүхэд асрах чөлөөтэй ажилтны оронд 2, хүүхэд асрах чөлөөний хугацааг сунгасан 3, туршилтын хугацаа дуусаж үндсэн ажилтнаар томилогдсон 7, үндсэн ажилтнаар 9, шинээр 12 ажилтан ажилд авсан. Ажилтны хүсэлтээр 11, ажил олгогчийн санаачилгаар 4, нийт 15 ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцалж ажлаас чөлөөлж, 2 ажилтныг шилжүүлэн томилсон.	100
<i>4.10 Засгийн газрын бодлого, дээд газраас гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг нэгтгэн, тогтоосон хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлэх, тайлагнах</i>				

4.10.1	Засгийн газрын бодлого, дээд газрын хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд хүргүүлэх, тайлагнах	Жилийн эцэст: 2022 онд дээд байгууллагаас ирүүлсэн тогтоол шийдвэрийн биелэлтийг гарган дээд байгууллагад хүргүүлсэн байна.	Дээд байгууллагуудаас ирүүлсэн нийт 13 тогтоол шийдвэрүүдийн биелэлтийг нэгтгэн удирдах дээд байгууллагад заасан хугацаанд тайлагнаж ажилласан.	100
4.10.2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2023.04.17-ны өдрийн 01 тоот албан даалгавар, БХБЯ-ны 2023.05.08-ны өдрийн 3/1668 тоот “Хуулийн хэрэгжилтийг хангаж, тайлан ирүүлэх тухай” албан тоотыг үндэслэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан 68 төрлийн мэдээ мэдээллийг компанийн албан ёсны www.tosk.gov.mn вэб сайтад бүрэн байршуулж, Гүйцэтгэх захирлын 2023.05.15-ны өдрийн 1/570 тоот албан бичгээр БХБЯ-д тайлангийн хамт хүргүүлсэн. Ерөнхий сайдын албан даалгаврын хүрээнд 2023.03.27-ны өдөр Shilen.gov.mn сайт ашиглалтад орсон бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу компанийн мэдээллийг илгээж, ил тод байршуулсан.	100
4.11 Компанийн үйл ажиллагааг сурталчлах, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, системийг хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, дотоод болон гадаад сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангах				
4.11.1	Компанийн үндсэн үйл ажиллагааны талаар бодлогын чанартай мэдээ мэдээлэл бэлтгэх, хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, ажлын явцыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэх	Компанийн 2022 оны “Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтний үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллана.	Компанийн Пэйж болон Твиттер хуудсанд – 250 постер бэлтгэж оруулсан. Сайтад 67 мэдээ бэлтгэж – Бэлтгэсэн мэдээллийг 65 ХМХ-ээр түгээсэн /пэйж 10, сайт 45, телевиз 10/. Пэйж болон твиттер хуудсанд хандаж санал хүсэлтээ ирүүлсэн 358 иргэдэд хариулт өгч ажилласан.	100
4.11.2	Компанийн хэмжээнд мэдээллийн технологийн бодлогыг хэрэгжүүлэх, цахим системийг хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, дотоод болон гадаад сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангах	Эрсдэлийн үнэлгээнд суурилан хяналтыг сонгох, программ техникийн шийдлийг нэвтрүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8	Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг цахим хуудсанд бүрэн байршуулсан. Албан бичиг солилцооны дундын систем (DOCX)-тэй холбогдсон. Түрээсийн шинэ программыг turees.tosk.gov.mn гэсэн домэйн нэр үүсгэж VPS серверийн тохиргоог хийж онлайн орчинд ажилладаг болгосон. Үндэсний Дата Төвөөс VPS /виртуал сервер/ түрээсэлсэн. Шинээр орсон, гарсан ажилчдын И-мэйл хаягийг үүсгэж, устган бусад	100

		дугаар зүйлд заасан мэдээллүүдийг оруулж ажиллана.	ажилчдын цахим шуудангийн хаягийн хэвийн ажиллагааг хангасан. Энгийн интерфейстэй сүүлийн үеийн технологи ашиглан бүрэн динамик уян хатан веб сайт бүтээсэн.	
4.12 Компанийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын дагуу хөтлөн явуулах				
4.12.1	Компанийн архивын баримтыг нягтлан шалгах, эмхлэн цэгцлэх, тоо бүртгэл хөтлөх, хадгалалт хамгаалалтыг сайжруулж, архивд баримт хүлээж авах, хадгалах хугацаа дууссан баримтыг шилжүүлэх, 2022 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулан батлуулах, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зааврын дагуу хөтлөн явуулах, хэрэгжилтийг хангуулах	2022 онд хөтлөгдөж дууссан байнгын бол түр хадгалах хадгаламжийн нэгжүүдийг архивлах ажлыг 2023 оны 01 дүгээр улиралд багтаан зохион байгуулж, Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан батлуулан Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зааврын дагуу хөтлөн явуулсан байна	Компанийн архивын нөхөн бүрдүүлэлтийн эх үүсвэр болох зохион байгуулалтын нэгжүүдээс өмнөх жилийн Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байнга болон түр хадгалах 182 хадгаламжийн нэгжийг холбогдох журмын дагуу архивд хүлээн авсан.	100
4.13 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн оролцох				
4.13.1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 200 ширхэг мод тарьж ургуулах	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 200 ширхэг мод тарьж ургуулсан байна.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн улс орон даяар өрнөж байгаатай холбогдуулан модны суулгац худалдан авах төсвийг зорилтот түвшинд суулган батлуулсан ба 2023 оны 10 дугаар сард үндэсний мод тарих өдөр тус үйл ажиллагааг хэрэгжүүлж компанийн нийт ажилтнууд 200 мод тарьсан.	100
4.14 Барилга, хот байгуулалтын салбарт Жендерийн болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх				
4.14.1	Жендерийн үндэсний хорооны зохион байгуулдаг сургалтуудад хамрагдах, эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл болон нийгэмд гүйцэтгэх үүрэг оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн сургалт, судалгаа, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг албан хаагчдын дунд өрнүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар	Жендерийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, жендерийн боловсролыг олгох болон, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар сургалт, судалгаа, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хамт олны дунд зохион байгуулж, Жендерийн эрх	Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” сэдэвт цахим зөвлөлдөх уулзалтад газар, хэлтсийн дарга нар, “Жендерийн тэгш байдлыг хангах салбар дундын хамтын ажиллагаа” сэдэвт сургалтад 2 мэргэжилтэн, “Жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, ажлын байрны стрессгүй орчин” сургалтад 1 эрэгтэй, 2 эмэгтэй ажилтан тус тус хамрагдсан. Компанийн албан хаагчдад сургалт сурталчилгааны материалуудыг	100

сургалт, арга хэмжээнд хамрагдах	тэгш байдлын хангах тухай хууль, бодлого шийдвэрийн талаар зохион байгуулсан хурал, зөвлөгөөн, семинарт хамрагдсан байна.	нийтлэн сурталчлахаас гадна компанийн Гүйцэтгэх захирлын 2023.05.19-ний өдрийн А/30 тоот тушаалаар Ёс зүйн зөвлөлийг байгуулж, хавсралтаар ажиллах журмыг батлуулан ажиллаж байна. Мөн 2023.09.07-ны өдөр БХБЯ-ны ахлах шинжээчид жендерийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, жендерийн зөвлөлийн гишүүдээс авах тодруулга өгсөн. Компанийн нийт албан хаагчид “Хүндлэл хамгийн тод гэрэл” аянд нэгдсэн.	
----------------------------------	---	---	--

“Төрийн орон сууцны корпорацн” ТӨХХК-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд үр дүнгүй, 0%-тай арга хэмжээ 1 байна. Үүнд:

1. Арга хэмжээ 1.2.4. “Эко Яармаг-1” төслийн хоёрдугаар ээлжид хамрагдсан 65 нэгж талбарын газрыг чөлөөлж, хог хаягдлыг цэвэрлэх, хөрсний ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг гүйцэтгүүлэх;

Зорилтот түвшин: Төслийн хоёрдугаар ээлжийн 65 нэгж талбарын газрыг чөлөөлөх ажлыг зохион байгуулсан байна.

Эрчимжүүлэх шаардлагатай, 50 хувьтай 2 арга хэмжээ байна. Үүнд:

1. “Эко Яармаг-1” төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг шинэчлэх ажлыг гүйцэтгэгч байгууллагатай хамтран зохион байгуулах;

Зорилтот түвшин: Төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын шинэчилсэн зураг төсөлтэй болсон байна.

2. “Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт тоног төхөөрөмж”-ийг цаашид эзэмших байгууллагын баланст шилжүүлэх ажлыг Хөгжлийн банкны хамтарсан ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулах “Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт тоног төхөөрөмж”-ийг цаашид эзэмших байгууллагын баланст шилжүүлсэн байна.

Зорилтот түвшин: “Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт тоног төхөөрөмж”-ийг цаашид эзэмших байгууллагын баланст шилжүүлсэн байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

“Төрийн орон сууцны корпорацн” ТӨХХК–ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар **92,4%**-тай, **“тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлэв.

ТОСК нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө 61 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Нэгдүгээр хэсэгт “Бодлогын баримт бичигт

тусгагдсан зорилт, арга хэмжээ"-нд 14 арга хэмжээ төлөвлөсөн ба түүний хэрэгжилт 82,8 %-тай байна.

Цаашдаа 2024 оны төлөвлөлтдөө анхаарч, орон сууцны Солонго -1,2 хороолол, Эко Яармаг -1, Залуус -1 хороолол барих төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх болон УИХ, Засгийн газраас баталсан бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

Орон сууцны Солонго -1,2 хороолол, Эко Яармаг -1, Залуус -1 төслүүдийн хэрэгжилт хангалтгүй, төслүүдийн барилга, угсралтын ажлуудыг анхаарч хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай.

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Нэг. "ТОСК" ТӨХХК /Б.Эрдэнэбулган/-д зөвлөмж болгох нь:

1. Тус компанийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 0-50 хувьтай 3 арга хэмжээг 2024 оны төлөвлөгөөндөө тусган бүрэн хэрэгжүүлж ажиллах;

2. ТОСК-аас хариуцан хэрэгжүүлж буй орон сууцны "Солонго -1,2", "Эко Яармаг-1", "Залуус -1" төслүүдийн хэрэгжилт удаашралтай, хугацаа алдаж байгаа тул төслийн хэрэгжилт удаашралтай байгаа шалтгааныг тодорхойлж, 2024 оны төлөвлөгөөнд тусгаж төслүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх;

3. "Алсын хараа 2050", Шинэ сэргэлтийн бодлого, Үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 150000 айлын орон сууцны хөтөлбөрт туссан хүн амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг 2024 оны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх;

4. Хэрэгжүүлж буй төсөл тус бүрээр данс хөтөлж, төсөв төлөвлөлтөө сайжруулах;

5. Үндэсний аудитын газрын албан шаардлага, акт, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх;

6. Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хангах, ТОСК-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ирүүлэхдээ Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан "Улсын салбарын дотоод аудитын аргачлал"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон тус яамнаас хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн биелэлттэй хамт яаманд ирүүлж ажиллах шаардлагатай байна.

ХЯНАСАН:


МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА



Х.ГАН-ОЧИР

БОЛОВСРУУЛСАН:

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ШИНЖЭЭЧ



Б.ЦОЛМОН-ЭРДЭНЭ

